



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

23119 Чингис хот, Хэнтий аймаг,
Утас/Факс: 70-56-24-12
E-mail: infoazdtg@khentii.gov.mn

БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ
ДАРГА П.ЧИНБАТ ТАНАА

2022.05.03 № 7/966
танай _____-ны № _____-т

Дүгнэлт, зөвлөмж хүргүүлэх тухай

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 04 дугаар сарын 12-ний өдөр тус сумын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах үйл ажиллагаа хийсэн дүнг удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Дүгнэлт: Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг хяналтад аваагүйн улмаас аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд руу хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн биелэлт хугацаандаа явсан эсэх, ямар биелэлт яваад хэрхэн үнэлэгдэж байгааг мэддэггүй, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж эзэнжүүлээгүй. Сумын Засаг даргын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг уялдуулж, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг зөв тодорхойлж дахин төлөвлөх шаардлагатай.

Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасны хадгалалт, хамгаалалтын найдвартай байдал бүрэн хангагдаагүй. Албан хэргийн үйл ажиллагаанд бичиг хэргийн ажилтны хэрэглэх “Хуулбар үнэн, Байгууллагад баримт бичиг хүлээн авсан”, “Боловсруулсан, хянасан” дардасгүй. Хэвлэмэл хуудасны эхийг хянуулаагүй, хэвлэгч /принтер/-ээр хэвлэсэн стандартын бус хэвлэмэл хуудас ашиглаж байна. Хэвлэмэл хуудасны индекс батлаагүй, зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмж:

1. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн холбогдох заалтуудыг жил бүр жагсаалт гарган шинэчлэн батлуулж, биелэлтийг агентлаг руу явуулахдаа сумын Засаг даргын Тамгын газар хяналт тавих
2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг зөв тодорхойлох, төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгууллагын

2.

гүйцэтгэлийн төлөвлөгөөнд уялдуулан зорилтыг арга хэмжээ болгон нарийвчлан задалж боловсруулах

3. Аймгийн Засаг даргын 2021 оны А/105 дугаар захирамжийн хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг хэрэгжүүлэх аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.3.1-д заасны дагуу төсөвт байгууллагуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах

4. Үнэлгээний төхөөрөмжийн журмын хэрэгжилтийг хангаж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчээр үнэлүүлж, АХХ-ын журамд заасны дагуу шаардлага хангасан тайлан, мэдээг үнэн бодитой гаргаж сар бүрийн 25-ны дотор Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэх

5. Удирдлагууд болон нийт албан хаагчид www.erp.e-mongolia.mn системийг тогтмол ашиглаж, удирдлагууд хяналт тавьж, өргөдөл гомдлыг бүрэн гүйцэд шийдвэрлэж, тодорхой тэмдэглэгээ хийж хаах, цахим системд бүртгэж, шийдвэрлэх

6. Сумын мэдээлэл хүргэдэг хуудсуудыг идэвхтэй ажиллуулж тогтмол мэдээлэл оруулдаг байх, аймгийн Засаг даргын Тамгын газрын хуудсыг дагаж мэдээллийг сумын цахим хуудсуудаар хуваалцдаг байх, байгууллагын болон санхүүгийн мэдээллийг мэдээллийн самбарын байршуулж, тогтмол шинэчлэх,

7. Орон нутгийн төсвийн байгууллагуудад санхүүжилтийн эрх олгох ЗЭБ-1 маягтын дутууг гүйцээж жагсаалтыг сумын Засаг даргаар батлуулах

8. Засгийн газрын 2021 оны 226, 2020 оны 246 дугаар тогтоол, Архивын ерөнхий газрын даргын 2016 оны А/142 дугаар тушаал, Монгол Улсын стандарт MNS 5140-2:2021 Баримт бичгийн бүрдэл, тэдгээрт тавигдах шаардлага, MNS 5140-3:2021 Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлийг байрлуулахад тавигдах шаардлагыг баримтлан ажиллах

Зөвлөмжийн дагуу гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган биелэлтийг 2022 оны 05 сарын 13-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ГАНЧИМЭГ

